

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/175/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол Шинжлэх Ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АШБ	Анхан шатны баримт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НХМ	Нэг хэвийн маягт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

**ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ О.ПҮРЭВДУЛАМ ТАНАА**

2023.02.24 № 01/181

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 106,248.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторовн мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 1 удирдах, 13 гүйцэтгэх, 5 үйлчилгээний ажилтан, нийт 19 орон тоо батлагдсанаас бүрэн орон тоогоор ажилласан байна.

19020381

Сургуулийн захирал нь Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөж, 95.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБСУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Данс	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,737,288.58	140,610,920.80
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	106,248,724.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	106,248,724.28
3121	Төгрөг	-	106,248,724.28
31211	Төрийн сангийн харилцах	-	106,248,724.28
35	БАРАА МАТЕРИАЛ	37,737,288.58	34,362,196.52
354	Хангамжийн материал	37,737,288.58	34,362,196.52
35410	Бичиг хэргийн материал	1,472,650.00	1,647,650.00
35420	Аж ахуйн материал	35,890,838.58	32,714,546.52
35460	Хүнсний материал	373,800.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	423,520,424.96	399,204,306.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	423,520,424.96	399,204,306.33
392	Биет хөрөнгө	418,154,424.96	393,838,306.33
39201	Барилга, байгууламж	391,562,662.62	391,562,662.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,150,127.80)	(38,958,812.88)
39205	Машин, тоног төхөөрөмж	54,306,554.36	46,563,766.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,169,187.87)	(25,452,643.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,821,083.85	51,824,685.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,838,860.38)	(32,131,452.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,922,000.00	1,922,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,299,699.82)	(1,491,900.00)
393	Биет бус хөрөнгө	5,366,000.00	5,366,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,366,000.00	5,366,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	461,257,713.54	539,815,227.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	461,257,713.54	539,815,227.13
51	Засгийн газрын хувь оролцоо	461,257,713.54	539,815,227.13
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	375,255,248.95	375,255,248.95
51101	Өмч: -Төрийн өмч	375,255,248.95	375,255,248.95
512	Хуримтлагдсан үр дүн	84,644,539.81	163,202,053.40
51210	Өмнөх үеийн үр дүн	84,644,539.81	84,644,539.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	78,557,513.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,357,924.78	1,357,924.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	461,257,713.54	539,815,227.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	435,161,050.00	495,929,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,112,750.00	1,503,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	109,112,750.00	1,503,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	109,112,750.00	1,400,000.00
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	109,112,750.00	1,400,000.00
120009	Бусад орлого	-	103,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,723,800.00	69,553,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,723,800.00	43,385,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,723,800.00	43,385,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,324,500.00	424,872,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	26,167,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	26,167,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	342,898,653.99	417,371,786.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,898,653.99	417,371,786.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,554,083.61	382,650,251.18
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	216,188,850.62	235,861,195.88
210101	Цалин	136,663,104.53	175,638,802.88
210102	Нэмэгдэл цалин	55,130,388.09	49,004,781.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,095,999.00	-
210104	Урамшуулал	18,299,359.00	11,217,612.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,349,739.00	29,737,581.84
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,132,453.85	20,334,016.73
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,162,397.24	2,384,841.82
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,687,928.20	1,891,132.01
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	412,659.23	440,071.25
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,954,300.48	4,687,520.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,402,760.00	27,036,862.77
210301	Гэрэл цахилгааны зардал	1,817,160.00	5,630,404.77
210302	Түлш, халаалтын зардал	22,060,100.00	20,800,358.00
210303	Цэвэр, бохир усны зардал	525,500.00	606,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	914,250.00	5,943,142.06
210401	Бичиг хэргийн материал	100,000.00	-
210402	Тээвэр, шатахууны зардал	199,250.00	-
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	200,000.00	-
210404	Ном, хэвлэлийн зардал	30,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	270,000.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	115,000.00	-

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210408	Бараа материал акталсны зардал	-	5,943,142.06
2105	Нормативт зардал	12,343,530.00	45,431,700.00
210501	Эм	65,000.00	-
210502	Хоол	11,828,530.00	45,431,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	804,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	804,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,854,953.99	37,335,268.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,361,600.00	7,412,150.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	907,000.00	2,135,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,586,353.99	27,788,118.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,344,570.38	34,721,535.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,923,397.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,788,300.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,379,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,755,797.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,523,530.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,523,530.38	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,821,040.00	4,798,138.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,821,040.00	4,798,138.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	92,262,396.01	78,557,513.59
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	92,262,396.01	78,557,513.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	326,048,300.00	494,529,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	103,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	103,500.00
120009	Бусад орлого	-	103,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,048,300.00	494,425,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,723,800.00	43,385,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,723,800.00	43,385,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,324,500.00	424,872,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	26,167,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	26,167,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,048,300.00	384,808,575.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,048,300.00	384,808,575.72
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,703,729.62	350,087,040.49
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	216,188,850.62	235,845,811.37
210101	Үндсэн цалин	136,663,104.53	175,623,418.37
210102	Нэмэгдэл	55,130,388.09	49,004,781.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,095,999.00	-
210104	Үр дүнгийн урамшуулал	18,299,359.00	11,217,612.00
2102	Ажил ологчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,349,739.00	29,752,966.35
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,132,453.85	20,349,401.24
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,162,397.24	2,384,841.82
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,687,928.20	1,891,132.01
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	412,659.23	440,071.25
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,954,300.48	4,687,520.03
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	24,402,760.00	27,036,862.77
210301	Гэрэл цахилгааны зардал	1,817,160.00	5,630,404.77
210302	Түлш, халаалтын зардал	22,060,100.00	20,800,358.00
210303	Цэвэр, бохир усны зардал	525,500.00	606,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,051,050.00	-
210401	Бичиг хэрэг	100,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	199,250.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	-
210404	Ном, хэвлэл	61,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	-
2105	Нормативт зардал	13,767,330.00	45,057,900.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	-
210502	Хоол, хүнс	12,202,330.00	45,057,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	804,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	804,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,444,000.00	11,089,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,537,000.00	8,779,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	907,000.00	2,310,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,344,570.38	34,721,535.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,923,397.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,788,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,379,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,755,797.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,523,530.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,523,530.38	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,821,040.00	4,798,138.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,821,040.00	4,798,138.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	109,720,724.28
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	3,472,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,472,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,472,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,472,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(3,472,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	106,248,724.28
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	106,248,724.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын Оруулсан капитал	Дахин үнэлгээний Нөөц	Хуримтлагдсан Үр дүн	Засгийн газрын хувь Оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	375,255,248.95	1,385,813.20	5,170,356.53	381,811,418.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,255,248.95	1,385,813.20	5,170,356.53	381,811,418.68
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(12,816,101.15)	(12,816,101.15)
D01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	84,644,539.81	461,257,713.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	84,644,539.81	461,257,713.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	78,557,513.59	78,557,513.59
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	163,202,053.40	539,815,227.13

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	424,872,300.00	318,727,075.72	106,145,224.28	75.0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	424,872,300.00	318,727,075.72	106,145,224.28	75.0
Бараа, үйлчилгээний зардал	421,116,500.00	314,971,278.72	106,145,221.28	74.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,106,300.00	226,055,883.37	94,050,416.63	70.6
Үндсэн цалин	262,077,400.00	167,891,413.37	94,185,986.63	64.1
Нэмэгдэл	53,639,700.00	47,349,343.00	6,290,357.00	88.3
Урамшуулал	4,389,200.00	10,815,127.00	(6,425,927.00)	246.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,035,600.00	28,491,995.35	11,543,604.65	71.2
Тэтгэврийн даатгал	27,231,400.00	19,487,205.04	7,744,194.96	71.6
Тэтгэмжийн даатгал	3,201,100.00	2,285,148.12	915,951.88	71.4
ҮОМШӨ ний даатгал	2,560,800.00	1,811,297.05	749,502.95	70.7
Ажилгүйдлийн даатгал	640,200.00	420,212.51	219,987.49	65.6
Эрүүл мэндийн даатгал	6,402,100.00	4,488,132.63	1,913,967.37	70.1
Нормативт зардал	45,059,000.00	45,057,900.00	1,100.00	100.0
Хоол, хүнс	45,059,000.00	45,057,900.00	1,100.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,258,000.00	804,500.00	453,500.00	64.0
Мэдээллийн технологийн зардал	1,258,000.00	804,500.00	453,500.00	64.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14,657,600.00	14,561,000.00	96,600.00	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	12,347,600.00	12,251,000.00	96,600.00	99.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,310,000.00	2,310,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,755,800.00	3,755,797.00	3.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	3,755,800.00	3,755,797.00	3.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,755,800.00	3,755,797.00	3.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	424,872,300.00	424,872,300.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	424,872,300.00	424,872,300.00	-	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	424,872,300.00	424,872,300.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	106,248,724.28	(106,248,724.28)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	19	19	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.0
Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	127	127	-	100.0

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,385,900.00	38,587,761.77	4,798,138.23	88.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	43,385,900.00	38,587,761.77	4,798,138.23	88.9
Бараа, үйлчилгээний зардал	43,385,900.00	38,587,761.77	4,798,138.23	88.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,686,500.00	9,789,928.00	896,572.00	91.6
Үндсэн цалин	8,267,600.00	7,732,005.00	535,595.00	93.5
Нэмэгдэл	2,005,500.00	1,655,438.00	350,062.00	82.5
Урамшуулал	413,400.00	402,485.00	10,915.00	97.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,335,600.00	1,260,971.00	74,629.00	94.4
Тэтгэврийн даатгал	908,400.00	862,196.20	46,203.80	94.9
Тэтгэмжийн даатгал	106,800.00	99,693.70	7,106.30	93.3
ҮОМШӨ ний даатгал	85,500.00	79,834.96	5,665.04	93.4
Ажилгүйдлийн даатгал	21,200.00	19,858.74	1,341.26	93.7
Эрүүл мэндийн даатгал	213,700.00	199,387.40	14,312.60	93.3
Байр ашиглалттай холбоотой тогмол зардал	30,863,800.00	27,036,862.77	3,826,937.23	87.6
Гэрэл цахилгаан	7,637,900.00	5,630,404.77	2,007,495.23	73.7
Түлш, халаалт	22,060,400.00	20,800,358.00	1,260,042.00	94.3
Цэвэр, бохир ус	1,165,500.00	606,100.00	559,400.00	52.0
Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,385,900.00	43,385,900.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,385,900.00	43,385,900.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	43,385,900.00	43,385,900.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	19	19	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.0
Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	127	127	-	100.0

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	26,167,600.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	26,167,600.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26,167,600.00
Бусад урсгал шилжүүлэг	-	26,167,600.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,788,300.00
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	-	13,379,300.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	26,167,600.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	26,167,600.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	26,167,600.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх, сурагчдын сонирхолд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг эзэмшүүлэх” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвшүүлэх;
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх гэж тодорхойлсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэг нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 04 дүгээр сарын 2-ний өдөр батлагдсан./
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
7. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам”-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал

8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,183.1 мянган төгрөгөөр буюу 38.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	106,248.72	106,248.72
Бараа материал	37,737.29	34,362.20	(3,375.09)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	423,520.42	399,204.31	(24,316.12)
Нийт хөрөнгийн дүн	461,257.71	539,815.23	78,557.51
Засгийн газрын хувь оролцоо	461,257.71	539,815.23	78,557.51
өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	461,257.71	539,815.23	78,557.51

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос нэмэгдэж, материаллаг өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 106,248.72 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 765,041.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 765,041.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 296,783.0 мянган төгрөгөөр бууруулж, 468,258.2 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 424,872.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 43,385.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 424,872.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43,385.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 4,798.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 357,314.8 мянган төгрөг буюу 76.3 хувьтай байгаа нь бараа, үйлчилгээний зардлын төсвийг 110,943.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,700,000.00	1,700,000.00	0.00	100.0
2	81807-Хүүхдийн хоол	45,059,000.00	45,057,900.00	1,100.00	100.0
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,645,300.00	1,645,000.00	300.00	100.0
4	81823-Боловсролын байгууллагын багш	1,700,000.00	1,604,000.00	96,000.00	94.4

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан					
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	348,998,500.00	244,399,255.10	104,599,244.90	70.0
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	25,769,500.00	24,320,920.62	1,448,579.38	94.4
Дүн		424,872,300.00	318,727,075.72	106,145,224.28	75.0
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	31,363,800.00	27,536,862.77	3,826,937.23	87.8
2	80112-Нийтлэг үйлчилгээ	12,022,100.00	11,050,899.00	971,201.00	91.9
Дүн		43,385,900.00	38,587,761.77	4,798,138.23	88.9
Нийт дүн		468,258,200.00	357,314,837.49	110,943,362.51	76.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3; 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 3 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийг олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.8-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгт төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 342,898.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,429.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,400.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг байршуулаагүй, 11 удаагийн 268,274.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 381,898.9 мянган төгрөгөөр буюу 113,624.2 мянган төгрөгөөр

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

илүү байршуулж, 9 удаагийн 152,459.2 мянган төгрөгийн орлого, 3 удаагийн 24,406.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 7 удаагийн 24,935.7 мянган төгрөгийн орлого, 25 удаагийн 50,719.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд хуулийн хугацаанд холбогдох мэдээллийг тогтмол үнэн зөв, бүрэн байршуулах албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Балансын дансны жагсаалт"-ын дагуу тайлагнагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын комисст санхүүгийн мэргэжлийн ажилтан ажиллуулах зөвлөмж өгөв.

Шалгадагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 2 хувь хүн, хуулийн этгээдийн төлбөрийн цахим баримт 2,192.2 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тайлагнаж байх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, 333,849.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг Төв аймгийн төрийн аудитын газар албан бичгээр хүргүүлсэн боловч 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	333,849.3	2	333,849.3	66.7
Нийт дүн	3	333,849.3	2	333,849.3	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 953.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 953.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй;
2. Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг 953.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг;
3. Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 461,257.3 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 259.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 259.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Цалингийн дэлгэрэнгүй тооцооллыг давтан тулгахад нэг ажилтны татвар ногдуулах орлогоос 259.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;"
санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй
нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын
баримт бичгийг боловсруулж мөрдөх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын
15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал
илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 461,257.3 мянган төгрөгийг	1	461,257.3	-	-	1	461,257.3	1	461,257.3	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг 953.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	953.1	-	-	1	953.1	1	953.1	-	-	-	-
Дүн	3	462,210.4	-	-	3	462,210.4	3	462,210.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн дэлгэрэнгүй тооцооллыг давтан тулгахад нэг ажилтны татвар ногдуулах орлогоос 259.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.	1	259.4	-	-	1	259.4	-	-	-	-	-	-
Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	259.4	-	-	1	259.4	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг байршуулаагүй, 11 удаагийн 268,274.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 381,898.9 мянган төгрөгөөр буюу 113,624.2 мянган төгрөгөөр илүү байршуулж, 9 удаагийн 152,459.2 мянган төгрөгийн орлого, 3 удаагийн 24,406.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 7 удаагийн 24,935.7 мянган төгрөгийн орлого, 25 удаагийн 50,719.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.	1	24,406.2	-	-	1	24,406.20	-	-
Дүн	1	24,406.2	-	-	1	24,406.2	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс , нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 2 хувь хүн, хуулийн этгээдийн төлбөрийн цахим баримт 2,192.2 мянган төгрөгөөр дутуу байна.	1	2,192.2					1	2,192.2
Дүн	3	2,192.2	-	-	3	-	1	2,192.2
Нийт дүн	4	26,598.4	-	-	4	24,406.2	1	2,192.2